209

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 27 өдөр Дугаар А/41 Сүмбэр сум

Байгууллагын Залуучуудын хөгжлийн
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан "Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр"-ийн 5.2.8 дахь хэсэг, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Залуучуудын үнэлэмжийг нэмэгдүүлж, тэдний хөгжил, оролцоо, санал санаачилга, шинэлэг зан үйлийг дэмжих, эрхийг нь хангахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах зорилгоор байгууллагын дэргэдэх "Залуучуудын хөгжлийн зөвлөл"-ийг байгуулсугай.

2.Залуучуудын хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хамт олноос авсан саналыг үндэслэн хавсралтаар батлалсугай.

3.Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм"-д нийцүүлэн зохион байгуулан үр дүнг улирал тутам тайлагнаж ажиллахыг Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн (Б. Урангоо)-д даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн (Г. Мөнхдэлгэр)-т даалгасугай.

ДАРГА Ц.ОЮУНБИЛЭГ

9018379
АТАЗ41Z 3219110003

D:/Бичиг хэрэг /тушаал

21007 5

210

ГБХЗХгазрын даргын 2021 оны
.....05.....сарын.....27.....-ны өдрийн.....А/141.....
дугаар тушаалын хавсралт

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ТЭРГҮҮН: Б. Урангоо-Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: У. Хандсүрэн-Сэтгэл зүйч

ГИШҮҮД: Б. Шархүү- Хүүхдийн эрх хамгаалал хариуцсан мэргэжилтэн, Хүүхдийн эрхийн Улсын байцаагч

Г.Мөнхдэлгэр-Хяналт шинжилгээ,үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

Г. Мөнхчимэг-Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Г. Хоролгарав- Түр хамгаалах байрны нийгмийн ажилтан

D:/Бичиг хэрэг /тушаал